



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 4/07

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 65 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 75,106,737 төгрөг /далан таван сая нэг зуун зургаан мянга долоон зуун гучин долоо/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101210021

“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
Нэг. Иргэдэд туслах сангийн 2021 оны төсвөөс:		
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНПУ-д сурч байгаад 2020.06.08-нд зуурдаар нас барсан Б.Т-ийг оршуулахтай холбоотой зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	БНСУ-ын Сөүл хотын Ёнсэй их сургуулийн эмнэлэгт 2020 оны 10 дугаар сарын 19-ны өдөр зүрхний хагалгаанд орж, эмчилгээ авалгүй нас барсан О.О-ийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	4,212,000 төгрөг
3	БНТУ-д амьдарч ажиллаж байгаад 2020.10.19-нд өвчний улмаас нас барсан Ч.Б-ын шарилыг Франкфуртээс Берлин хүргэхэд тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэж хүргэсний зардал,	8,695,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
4	БНСУ-ын Чэйл эмнэлэгт эмчилгээ хийлгэж буй Д.Г-ын эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
5	Австралийн Квинсландийн хүүхдийн эмнэлэгт цусны хорт хавдар (Acute Lymphoblastic Leukaemia)-тай гэж оношлогдон эмчлүүлж байгаа Г.Э-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	2,850,000 төгрөг
Хоёр: Санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгнөөс:		
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
6	Коронавируст халдварын улмаас БНСУ-д гацаж нутаг буцаж ирсэн иргэн Цэрэвсүрэнгийн Энхтуяагийн Монгол руу буцах болон тусгаарлах байрны төлбөр,	2,050,000 төгрөг
7	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн А.Э-ын Монгол руу буцах болон тусгаарлах байрны төлбөр,	2,050,000 төгрөг
8	БНСУ-д ял эдэлж суллагдсан иргэн С.Н-ийн Монгол руу буцах онгоцны тийзийн төлбөр,	1,340,000 төгрөг
9	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Б.А, түүний эхнэр С.О болон 6 настай хүүхдийн тусгаарлах байрны төлбөр,	1,850,000 төгрөг
10	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн П.Б, түүний 1 хүүхдийн тусгаарлах байрны төлбөр,	1,140,000 төгрөг
11	Коронавируст халдварын улмаас БНСУ-д гацаж нутаг буцаж ирсэн иргэн З.Х-ийн Монгол руу буцах болон тусгаарлах байрны төлбөр,	2,050,000 төгрөг

12	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Г.Г-ын Монгол руу буцах онгоцны тийзийн зөрүү болон тусгаарлах байрны төлбөр,	1,251,400 төгрөг
13	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Л.Б, түүний эхнэр Д.У болон 3 хүүхдийн тусгаарлах байрны төлбөр,	2,990,000 төгрөг
14	Коронавируст халдварын улмаас БНСУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Э.А-ын Монгол руу буцах болон тусгаарлах байрны төлбөр,	2,050,000 төгрөг
15	Коронавируст халдварын улмаас БНТУ-д гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.Б, түүний нөхөр Б.Б болон охин Б.Б нарын тусгаарлах байрны төлбөр,	1,850,000 төгрөг
16	Коронавируст халдварын улмаас БНТУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.Б-ын тусгаарлах байрны төлбөр,	710,000 төгрөг
17	Коронавируст халдварын улмаас БНТУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ч.Д-ын тусгаарлах байрны төлбөр,	710,000 төгрөг
18	Коронавируст халдварын улмаас БНТУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Н.О-ын тусгаарлах байрны төлбөр,	710,000 төгрөг
19	Коронавируст халдварын улмаас БНТУ-д очоод гацаж нутаг буцаж ирсэн иргэн Л.Б, түүний хүү Б.Ч нарын тусгаарлах байрны төлбөр,	1,140,000 төгрөг
20	Коронавируст халдварын улмаас БНТУ-д гацаж нутаг буцаж ирсэн иргэн Э.Э, түүний нөхөр Л.Н, хүү Н.Э, дүү Э.Э нарын тусгаарлах байрны төлбөр,	2,560,000 төгрөг
21	Коронавируст халдварын улмаас БНТУ-д гацаж нутаг буцаж ирсэн Э.А, эхнэр Б.Л нарын тусгаарлах байрны төлбөр,	1,420,000 төгрөг
22	Коронавирусын халдвар авч Германд тусгаарлагдаж эмчлүүлсэн иргэн Ц.Ц-д үзүүлэх дэмжлэг,	2,000,000 төгрөг
23	Коронавирусын халдвар авч Германд тусгаарлагдаж эмчлүүлсэн иргэн Х.М-ийн тусгаарлах байрны төлбөр,	3,800,000 төгрөг
24	Коронавируст халдварын улмаас Колумби Улсын Богота хотноо гацаж нутаг буцаж ирсэн иргэн Э.Ү болон түүний бага насны 2 хүүхдийн онгоцны тийзийн зөрүү төлбөр болон тусгаарлах байрны төлбөр,	2,955,250 төгрөг
25	БНЧехУ-д амьдарч буй хараагүй, өндөр настан иргэн Д.С-ийн тусгаарлах байрны зардал,	710,000 төгрөг
26	Тусгай үүргийн нислэг цуцлагдсантай холбогдуулан Л.А-ийн Бухарест-Франкфуртын тийзийн төлбөр	951,587 төгрөг
27	БНХАУ-д ял эдэлж суллагдсан 16 иргэний тусгаарлах байр болон тээврийн зардал	5,193,000 төгрөг
28	Кубад цар тахлын улмаас хүнсний хомсдол үүсч, оюутнууд наад захын хэрэгцээт хоол хүнсээ авч чадахгүй байгаа 19 оюутанд үзүүлэх дэмжлэг,	6,868,500 төгрөг
Дүн		75,106,737 төгрөг

Нийт дүн **75,106,737** /далан таван сая нэг зуун зургаан мянга долоон зуун гучин долоо/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

Улаанбаатар хот

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 19/18

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2021 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 6 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 26,168,150 /хорин зургаан сая нэг зуун жаран найман мянга нэг зуун тавь/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас, 60 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 28,031,900 /хорин найман сая гучин нэгэн мянга есөн зуу/ төгрөгийг Улсын онцгой комиссын даргын 2020 оны 08 дугаар сарын 18-ны шийдвэрийн дагуу Иргэдэд туслах санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгийн хөрөнгөөс тус тус гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101210048

“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
Нэг. Иргэдэд туслах сангийн 2021 оны төсвөөс:		
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-ын Сөүл хотод 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр нас барсан Д.Ц-ыг оршуулахтай холбоотой зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	БНСУ-д 2021 оны 1 дүгээр сарын 21-нд зуурдаар нас барсан П.Б-ын шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
3	2020 оны 11 дүгээр сард ослын улмаас нүдэндээ хүнд гэмтэл авч Москвагийн МНТК “Микрохирургия глаза” эмнэлэгт эмчилгээ хийлгэж буй Москвагийн консерваторийн оюутан Т.М-ын эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
4	2019.12.22-ны өдөр нарны эрчим хүч хураагуурын үйлдвэрт ажиллаж байгаад ахлах ажилтны буруу зааврын улмаас өндөр хүчдэл(22900v)-д цохиулсан тул хоёр гараа мөр хүртэл тайруулж эмчилгээ хийлгэж буй М.У-ын эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
5	БНЭУлсад элэг солиулах хагалгаанд орж эмчилгээ хийлгэж буй Б.Ж-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг болох	5,000,000 төгрөг
4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
6	А.Н-ний иргэний шинэчилсэн бүртгэл, гадаад паспортын төлбөр болох,	168,150 төгрөг
Хоёр: Санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгнөөс:		
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
7	Хилийн чанадаас ОУШХБ-ын зардлаар ирсэн 22 иргэний тусгаарлах байрны зардалд зориулж төлбөр,	10,220,000 төгрөг
8	БНТУ-д Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн “Шоохондой” ардын циркийн ахлагч Т.Т тэргүүтэй 9 жиүжигний тусгаарлах байрны төлбөр,	4,590,000 төгрөг
9	БНТУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.Г, түүний хүү Г.М-ийн тусгаарлах байрны төлбөр,	820,000 төгрөг
10	БНТУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн С.Э, түүний охин Б.Ц-ын тусгаарлах байрны төлбөр,	1,020,000 төгрөг
11	БНСУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Индонез улсад сурдаг ¹ оюутан Т.З-ын	510,000 төгрөг

	тусгаарлах байрны төлбөр,	
12	Камбожид хулгай хийж байгаад баригдаж, 1 жилийн хорих ялаар шийтгэгдэн 2021.2.10 ны өдөр суллагдсан иргэн О.О-ийн тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
13	Беларусьт очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн П.Ө, түүний эхнэр Т.Б-ийн тусгаарлах байрны төлбөр,	1,020,000 төгрөг
14	Малайзад очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ц.М-ийн тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
15	Малайзад очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Б.С-ийн тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
16	ХБНГУ-д Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ч.Б-ийн тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
17	АНУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Г.Э, түүний эхнэр Ө.С-ийн тусгаарлах байрны төлбөр,	1,020,000 төгрөг
18	АНУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.М-ын тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
19	БНСУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ц.Х-ын тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
20	БНСУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.С, түүний зээ охин Г.Ү-ийн тусгаарлах байрны төлбөр,	1,020,000 төгрөг
21	БНТУ-д Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Э.Э, түүний 2 хүүхэд Б.Х, Б.А нарын тусгаарлах байрны төлбөр,	1,130,000 төгрөг
22	Япон-д Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн Ч.О, түүний өвөг эцэг Ч.Ч, эгч Ч.Ц нарын тусгаарлах байрны төлбөр,	1,530,000 төгрөг
23	БНХАУ-ын Харбин хотод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирж чадахгүй байгаа иргэнд Манжуур дахь Консулын газраас иргэн О.Т өгсөн дэмжлэг	130,500 төгрөг
24	БНХАУ-д ял эдэлж суллагдсан иргэн И.У, Л.Б, Б.М нарын тусгаарлах байрны зардал, шатхууны зардал,	2,161,400 төгрөг
Дүн		28,031,900 төгрөг

Нийт дүн **28,031,900** /хорин найман сая гучин нэгэн мянга есөн зуу/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар

А/29

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 6 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 30,000,000 /гучин сая/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас, 30 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 58,841,365 /тавин найман сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун жаран тав/ төгрөгийг Улсын онцгой комиссын даргын 2020 оны 08 дугаар сарын 18-ны шийдвэрийн дагуу Иргэдэд туслах санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгийн хөрөнгөөс тус тус гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
Нэг. Иргэдэд туслах сангийн 2021 оны төсвөөс:		
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНТуркУ-ын КОЧ эмнэлэгт “Цусны хавдраас үүссэн тархины хавдар” гэсэн маш хүнд оноштой эмчилгээ хийлгэж буй Б.Н-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	БНСУ-д гэрээгээр хөдөлмөр эрхлэхээр ирж Янгсан хотод байрлах модны үйлдвэрт ажиллаж байгаад 3 давхар байрны дээвэр дээрээс унан баруун хөл болон зүүн гуяны яс нь хугарч удаан хугацаанд эмчилгээ хийлгэж буй И.Д-н эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
3	2018 оны 4 дүгээр сард баруун тархины булангийн хавдартай болох нь тогтоогдож БНСУ-ын Сөүлийн их сургуулийн эмнэлэгт гамма туяа эмчилгээ хийлгэж буй Б.Г-нийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
4	2021 оны 03 дугаар сарын 29-нд өндрөөс унаж хүндээр бэртэн БНСУ-ын Инчон хотын “Гил” эмнэлэгт эмчилгээ хийлгэж буй Б.Б-ын эмчилгээний зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
5	БНСУ-ын Сөүлийн их сургуулийн эмнэлэгт зүрхний судасны нарийсал болон цоорхойтой төрсөн, баруун тархины булангийн хавдартай болох нь тогтоогдож эмчилгээ хийлгэж буй Т.О-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
6	Австрали улсад 2020 оны 12 сарын 4-нд тархины хавдрын хагалгаа хийлгэсэн бөгөөд энэ үеэрээ уушигны хавдартай гэсэн онош тогтоогдон эмчилгээ хийлгэж буй Ц.Б-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
Хоёр: Санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгнөөс:		
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
7	АНУ-д 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдөр нас барсан Б.Т-ыг оршуулахтай холбоотой зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
8	Японд 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нас барсан Н.Н-ын шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
9	БНСУ-д 2021 оны 05 дугаар сарын 06-нд нас барсан О.А-ын шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
10	Турк улсад 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зуурдаар нас барсан Б.Ц-ын шарилыг эх оронд нь авч ирэх, эхнэр Э.С-ийн Станбул-Улаанбаатарын онгоцны зардал	6,197,500 төгрөг
11	Туркийн Истанбул хотын Ависэнна эмнэлэгт төрөхийн хүндрэл болон Ковид-19 халдвараас болж Шишли Хамидие Этфал эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлж байгаад 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр нас барсан Б.Э-ийн шарилыг эх оронд нь авч	4,997,500 төгрөг

	ирэх, нөхөр Х.Г, охин Г.Г-ийн тусгаарлах байрны зардал,	
12	БНСУ-ын Инчон хотын “Саран” асрамжийн эмнэлэгт 2 гаруй жилийн хугацаанд асаргаанд байж байгаад 4 дүгээр сарын 29-нд нас барсан Л.О эмнэлгийн төлбөрийг төлөх, өмгөөлөгч хөлслөх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
13	Японд сурч байгаад 2021 оны 05 дугаар сарын 13-нд зуурдаар нас барсан Э.О-ын шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
14	Англид очоод цар тахлын улмаас хөл хорионд орсон В.Б, В.О нарын тусгаарлах байрны зардалд зориулж,	1,020,000 төгрөг
15	БНСУ-д очсон боловч 2 сар ажил хийгээд коронавирусын улмаас хөл хорионд орсон Д.Э-ийн Сөүл-Улаанбаатарын тусгай үүргийн нислэгийн тийз, тусгаарлах байрны төлбөр,	1,519,800 төгрөг
16	БНСУ-д очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ш.О-ийн Сөүл-Улаанбаатарын тусгай үүргийн нислэгийн тийз, тусгаарлах байрны төлбөр,	1,519,800 төгрөг
17	Унгарын Будапешт хотод жирэмсэн байх үедээ ковид-19 халдвар авсан бөгөөд амаржсаны дараачаар биеийн байдал хүндэрч нас барсан Д.О-ийн нөхөр Д.Г, түүний хүүхдийн Будапешт-Улаанбаатар нислэгийн тийзийн төлбөр,	1,567,500 төгрөг
18	БНТУ-д очоод коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Д.Б-ын тусгаарлах байрны төлбөр,	510,000 төгрөг
19	Малайзад хулгайн хэрэгт холбогдож цагаачлалын газарт саатуулагдсан М.Н-ийн Куала-Лумпур-Сөүл-Улаанбаатарын тийз, тусгаарлах байрны төлбөр,	2,193,400 төгрөг
20	Малайзад цагаачлалын газарт саатуулагдсан И.М-ийн Куала-Лумпур-Сөүл-Улаанбаатарын тийз, тусгаарлах байрны төлбөр,	2,193,400 төгрөг
21	Польшид очоод Коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Г.М-ийн Варшав-Франкфурт, Франкфурт-Улаанбаатар нислэгийн тийз, тусгаарлах байрны төлбөр,	2,854,100 төгрөг
22	Японд очоод коронавируст халдварын улмаас гацаж нутаг буцаж ирсэн иргэн Ц.Б-ийн Токио-Улаанбаатар нислэгийн тийз, тусгаарлах байрны төлбөр,	1,697,100 төгрөг
23	Украин Улсад суралцаж буй нэр бүхий 9 оюутаны буцах зардал болон оюутны байрны төлбөрт дэмжлэг үзүүлж,	4,500,000 төгрөг
24	Монгол-Хятадын хилийн Хавирга-Архашаат боомт дээр гэмт хэргийн гэрч болж саатуулагдсанаас нутаг буцаж чадахгүй байгаа Н.А-д,	221,265 төгрөг
25	ОХУ-д ял эдэлж суллагдсан иргэн Ц.О-ын тусгаарлах байрны зардал,	350,000 төгрөг
26	БНХАУ-аас татан авсан 30 иргэнийг Замын-Үүдээс УБ хот руу тээвэрлэсэн автобусны төлбөр,	2,500,000 төгрөг
Дүн		88,841,365 төгрөг

Нийт дүн **88,841,365** / наян найман сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун жаран тав/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 27 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 64,578,580 /жаран дөрвөн сая таван зуун далан найман мянга таван зуун ная/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын дэд захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101210211

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д 2021.06.29-ний өдөр нас барсан А.Д-ийн шарилыг чандарласан зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	Малайз улсад 2021.05.03-ны өдөр нас барсан Г.М-ийн шарилыг чандарласан зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
3	БНСУ-ын Инчонд осолд орж 4 сар ухаангүй байж байгаад 2021.07.27-ны өдөр нас барсан Б.Б-ын шарилыг чандарласан зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
4	Чехийн Брно хотын эмнэлэгт сүрье, тархины миненгет хавсарсан оноштой эмчилгээ хийлгэж байгаа Б.Б-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
5	2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр БНСУ-ын Умард Чүнчон мужийн Асан хотод зам тээврийн осолд орсны улмаас хүндээр бэртэж, одоог хүртэл эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа А.О-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
6	БНСУ-д 2021.07.27-нд өндрөөс унаж хүнд гэмтэл авч эмнэлэгт хагалгаа хийлгэн эмчлүүлж байгаа С.Т-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
7	БНСУ-д 2021.05.24-нд тархины харвалтын улмаас тархины хагалгаа хийлгэсэн Ж.Э-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	2,927,800 төгрөг
8	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганкимаоду, Урадын төв хошууны хоорондох зам дээр зам тээврийн осолд орж, хүнд гэмтэл авсан Н.Б-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
9	2018 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Монгол-Хятадын хилийн Хавирга-Архашаат боомт дээр гэмт хэргийн гэрч болж саатуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл эх орондоо буцаж чадахгүй, хөл хорионы онцгой нөхцөлд гачигдалтай амьдарч байгаа Н.А-д дэмжлэг үзүүлж,	441,000 төгрөг
10	Амьдралын шаардлагаар Турк улс руу ажил эрхлэхээр яваад зардалгүйн улмаас нутаг буцаж чадахгүй байгаа Г.Д-ийн Истанбул-Улаанбаатарын тийзийн төлбөр,	3,000,000 төгрөг
11	Тайваны Нанхуа их сургуульд 2017 онд элсэн орж 2020 оны 9 дүгээр сард сургуулиасаа ар гэрийн шалтгаанаар гарсан Б.Б-ний Тайпэй-Сөүл-Улаанбаатарын тийзийн төлбөр,	3,100,000 төгрөг
12	Тайванийн их сургуулийг 2021 оны 6 дугаар сард төгссөн Ц.Т-ний Тайпэй-Сөүл-Улаанбаатарын тийзийн төлбөр, тусгаарлах байрны зардал,	3,100,000 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах; гэснийг үндэслэн;		

13	2020 оны 10 дугаар сард Малайз улсад очсон бөгөөд хулгайн хэргээр Малайзад хоригдож байгаад суллагдсан М.Н-ын Куала-Лумпур-Сөүл-Улаанбаатрын тийзийн төлбөр,	3,100,000 төгрөг
14	Тайландад хорих ял эдэлж байгаад Харьяатын газрын түр саатуулах байранд 7 сар болж байгаа М.Д-ын Бангкок-Сөүл-Улаанбаатарын нислэгийн тийзийн төлбөр,	3,100,000 төгрөг
4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
15	Эрээн хотын урьдчилан саатуулах төвөөс Хөх хотын хорих төв рүү шилжүүлсэн С.М-ийн буцах үнэмлэхний төлбөр,	105,840 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
16	БНСУ-ын Инчон хотод хүчирхийлэлд өртсөн иргэн Ж.Н-ийн хууль ёсны эрх ашгийг хамгаалуулах зорилгоор хөлсөлсөн өмгөөлөгчийн төлбөрийн тодорхой хэсэг,	3,000,000 төгрөг
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
17	Бээжин дэх ЭСЯ-ны Консулын хэлтсийн даргын БНХАУ-ын Ганьсу муж, Гуанжоу хотод томилолтоор ажиллах зардал,	5,498,940 төгрөг
18	БНХАУ-ын Хөх хотын хорих газарт хоригдож буй 10 эмэгтэйд дэмжлэг үзүүлж,	2,205,000 төгрөг
Дүн		64,578,580 төгрөг

Нийт дүн **64,578,580** /жаран дөрвөн сая таван зуун далан найман мянга таван зуун наян/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 14/196

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 13 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон хилийн чанадад хоригдож буй 117 иргэнд дэмжлэг үзүүлэх шаардлагатай 43,915,815 /дөчин гурван сая есөн зуун арван таван мянга найман зуун арван тав/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 5 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	"Цусны улаан эсийн цочмог хорт хавдар" оноштой БНТУ-д эмчлүүлж байгаад 2021.11.11-нд нас барсан иргэн О.А-ын шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	2,500,000 төгрөг
2	Францад нас барсан иргэн Н.Н-ийн шарилыг чандарлан эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	735,800 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах; гэснийг үндэслэн;		
3	2019 онд Тайландад хулгайн хэргээр 3 жилийн ял эдлээд 2021 оны 8 дугаар сард суллагдсан иргэн И.М-ын Монгол руу буцах болон PCR шинжилгээний төлбөр,	3,144,200 төгрөг
4	Паспортын зөрчлийн хэргээр /хуурамч нэрээр зорчсон/ Хонгконг-д саатуулагдаж 2021.11.15-нд суллагдсан иргэн Р.О-ны нутаг буцах зардлын тодорхой хэсэг,	1,0120,900 төгрөг
5	Кипр Улсад хууль бусаар нэвтэрсэн үндэслэлээр тус улсын Никозиа хотын дүрвэгсдийн байранд саатуулагдаж албадан буцаагдсан иргэн С.М, түүний эхнэр Т.Х нарын тусгаарлах байрны зардал,	700,000 төгрөг
6	БНХАУ-д ялын хугацаагаа дуусгаж, 2021 оны 9 дүгээр сард албадангаар Монгол Улс руу буцаагдсан иргэн Н.Г, О.Т, Х.Э, Б.О нарын тусгаарлах байрны зардал,	1,400,000 төгрөг
7	БНХАУ-д ялын хугацаагаа дуусгаж, албадангаар Монгол Улс руу буцаагдсан О.Т-ийн тусгаарлах байрны зардал	261,400 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
8	2019.12.21-нд согтуурсан үедээ хүйтэн мэс хэрэглэж хүний амь нас хөнөөхөөр завдсан хэргээр Унгар Улсын Сомбатхель хотод саатуулагдан шалгагдаж байгаа Г.Б-ний өмгөөллийн зардлын тодорхой хэсэг,	4,000,000 төгрөг
9	БНСУ-ын Өмнөд Гёнсан мужийн Янгсан хотын Янгсан Боми дунд сургуулийн 1-р ангид сурдаг, 13 настай, Монгол Улсын иргэн хохирогч охин Т.Е-ийн өмгөөллийн төлбөрийн тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
10	БНСУ-д хоригдож байгаа 28 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал,	9,567,525 төгрөг
11	Унгар Улсад саатуулагдан шалгагдаж буй иргэдийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал,	2,620,000 төгрөг
12	Бээжин дэх ЭСЯ-ны хамаарах тойрогт хоригдож байгаа 11 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал,	2,917,255 төгрөг
13	БНКазУ-д хоригдож байгаа 7 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал,	2,761,200 төгрөг

14	Шанхай хотод суугаа ЕКГ-аас тойрогт ял эдлэж буй 3 иргэнийг эргэхэд гарах зардал,	300,000 төгрөг
15	Хонгконг дахь ЕКГ-ын хариуцсан тойрогт хоригдож буй 13 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал,	1,601,035 төгрөг
16	Хөх хот дахь ЕКГ-ын хариуцсан тойрогт хоригдож буй 44 иргэнд дэмжлэг үзүүлэх зардал,	4,944,500 төгрөг
17	БНХАУ-ын Манжуур хотын шоронд Монгол Улсын иргэн Ө.Б-д дэмжлэг үзүүлэх	450,000 төгрөг
Дүн		43,915,815 төгрөг

Нийт дүн **43,915,815** /дэчин гурван сая есөн зуун арван таван мянга найман зуун арван тав/ төгрөг